



ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД
Н.ТАВИНБЭХ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreatkhural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2021.12.17 № 46

Асуулга тавих тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 39 дүгээр зүйлийн 39.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн дараах асуулгыг танд хүргүүлж байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 24 дүгээр тогтоолын хавсралтын 3.5 дахь зүйлийн "Эрчим хүчний найдвартай, аюулгүй, тогтвортой байдлыг бүрэн хангана" гэсэн зорилтын хүрээнд "Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станцын барилга угсралтын ажлыг эхлүүлж, Эрдэнэбүрэн-Мянгад-Улиастайн 220 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барина" гэж тусгасан.

Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын барилга угсралтын ажил эхэлж байгаа талаар, төслийн төлөвлөгөө, ач холбогдол, судалгаа, үнэлгээний талаар Монгол Улсын Ерөнхий сайд болон танай яамны зүгээс олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр удаа дараа холбогдох мэдээллийг хийж, мөн уг асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын нэр бүхий гишүүн Засгийн газрын холбогдох гишүүдэд асуулга тавьж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар асуулгын хариуг сонсож хэлэлцсэн.

Мөн уг бүтээн байгуулалтыг эсэргүүцэж тухайн бүс нутгийн иргэдийн төлөөлөл хэвлэл мэдээллийн хурал хийж, Увс аймгийн Өмнөговь сумын иргэдийн хурлын төлөөлөгчид энэ асуудлыг эсэргүүцсэн талаарх тогтоол баталсан зэрэг үйл явдлууд ар араасаа өрнөсөөр байна. Иймд Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын талаарх урд өмнө мэдээлэл хийгдсэн, Улсын Их Хурлаар танилцсан зэрэг асуудлаас гадна дараах асуулгыг танд хүргүүлж байна.

Нэг.Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын бүтээн байгуулалт, үйл ажиллагаатай холбоотойгоор усан сангийн талбайд мал аж ахуй эрхэлж байгаа нийт 258 айл, өрхийг 2022-2025 онд нүүлгэн шилжүүлэх асуудал төлөвлөгөөнд тусгагдсан байна. Монгол Улсын Засгийн газар "Эдгээр өрхийг одоо байгаагаас нь дордуулахгүйгээр нөхөн олговор олгож нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулна" гэжээ.

Нүүлгэн шилжүүлэх ажлын төсөвт 9.5 тэрбум төгрөг төлөвлөсөн байх бөгөөд энэхүү нөхөн олговор нь дээрх 258 айл, өрхөд ижил тэнцүү хуваарилах бус, харин тухайн айл, өрхийн өөрийн өмчийн эд хөрөнгийн үнэлгээнээс хамаарч зохих нөхөн олговрыг олгох төлөвлөгөөтэй ажиллаж байгаа талаар та бидэнд мэдээлэл өгсөн.

2021000209

Өөрөөр хэлбэл их хөрөнгөтэй айл их хэмжээний нөхөн олговор авах, хөрөнгө чинээ муутай айл нөхөн олговор бага хэмжээгээр авах байдлаар төлөвлөж байна гэх мэдээлэл байгаа бөгөөд жишээлбэл, 100 сая төгрөгийн үнэлгээтэй эд хөрөнгөтэй айл тэр хэмжээний нөхөн олговор авах, 100 мянган төгрөгийн эд хөрөнгөтэй айлд мөн тэр хэмжээний нөхөн олговор өгөхөөр төлөвлөжээ. Энэ нь байж боломгүй зохицуулалт бөгөөд ямар ч улс оронд аливаа бүтээн байгуулалттай холбоотой нөхөн олговрыг ард иргэддээ хуваарилахдаа хөрөнгө чинээгээр нь ялгаварлан гадуурхдаггүй.

Иймд энэхүү бүтээн байгуулалтын төсөлтэй холбоотой нөхөн олговрыг бүс нутгийн айл өрх бүрд ижил тэнцүү олгох, ингэхдээ нэг айлд 50 сая төгрөгөөс доошгүй хэмжээний нөхөн олговор олгох боломжтой эсэхийг судлан үзэж хариу ирүүлэх.

Хоёр.Монгол Улсын Засгийн газар уг бүтээн байгуулалтын ач холбогдлын талаар дурдахдаа "Эрдэнбүрэнгийн усан цахилгаан станцын бүтээн байгуулалтын ажил эхэлснээр бүс нутагт ажиллах хүчнийг татах бөгөөд боловсон хүчний урсгалыг нэмэгдүүлж бүс нутгийн зах зээлийн эрэлт хэрэгцээ тэлж, орон нутгийн аж үйлдвэрийн хөгжил, эдийн засгийн хөгжилд сайн дэмжлэг болно. Мөн үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн, Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжихэд томоохон хувь нэмэр оруулах болно" гэжээ.

Ховд аймаг нийт 88.9 мянган хүн амтай, 22.8 мянган өрхтэй 2.1 мянган албан байгууллага, аж ахуйн нэгжтэй, жилдээ 578.3 тэрбум төгрөгийн дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай. Барилгын материал үйлдвэрлэл, барилга, зам, эрчим хүчний угсралтын чиглэлээр 100, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн худалдааны чиглэлээр 400, хүнсний бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлээр 20, мах, махан, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлээр 10, ачаа тээврийн чиглэлээр 30 аж ахуйн нэгж, эрчим хүчний чиглэлээр 800 гаруй инженер, техникийн ажилтнууд байна. Эдгээр иргэд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих хүрээнд уг бүтээн байгуулалттай холбогдуулан ямар дэмжлэг, зохион байгуулалтын ажил төлөвлөгдөж байгаа талаар болон уг үйл ажиллагаанд хэрхэн оролцох талаар, мөн тэдгээр аж ахуй нэгжүүд нь үндэсний ассоциаци, консорциум хэлбэрээр нэгдэж уг үйл ажиллагаанд оролцох боломжтой эсэх талаар судлан хариу ирүүлэх.

Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцыг байгуулах энэхүү үйл ажиллагааны хүрээнд бүс нутгийн иргэд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, бизнесыг дэмжиж, уг бүтээн байгуулалтад оролцох боломж, нөхцөлөөр хангаж, бодит арга хэмжээ авч, төсөл хөтөлбөр боловсруулан ирүүлэх.

Гурав.Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын бүтээн байгуулалтын төслийн байгаль орчин, орон нутгийн иргэдэд учирч болзошгүй эрсдлийг тогтоосон үнэлгээ, болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тодорхойлсон тодорхойлолт зэргийг олон улсын хараат бус, хөндлөнгийн байгууллагаар хийлгэсэн эсэх талаар мэдээлэл өгөх.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3-д заасан хугацаанд ирүүлнэ үү.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Ш.АДЬШАА

2021000209